

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Бадарч	Дугаар	L163
Оршин суугаа аймаг	Сэлэнгэ	Оршин суугаа сум	Сант
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Цагаан толгойн хийд, Бүдүүний хурал	Сүм хийдийн дугаар	СЭСН 044, СЭСН 045
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 24	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Сэлэнгэ аймгийн Сант сумын Цагаан толгойн хийд, Бүдүүний хурал

Асуулт:- **Цагаан толгойн** хийдийн талаар ярьж өгөөч?

Хариулт:-**Цагаан толгойн** хийд чинь сумын төвийн цаад талын юун дээр байсан юм гэнэ лээ. Урагшаа орсон хамар байдаг юм, хуучин дээр үед бол засварын газар байсан тэрний тэнд хийд нь байсан юм гэсэн. Тэнд 50, 60-аад лам байсан юм болов уу даа. Тийм жижигхэн дуган.

Асуулт:-Хэдэн оны үед устгагдав?

Хариулт:-**Намайг төрөхөөс** өмнө устсан юм шиг байгаа юм даа.

Асуулт:-37 оны хэлмэгдүүлэлтийн үеэр үү, бүр өмнө нь үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Тэрний өмнөхөн дууссан юм шиг байгаа юм, 34, 35 оны үед дууссан болов уу? Гамингууд ч байсан байх, улаан хувьсгалч ч байсан байх. Ер нь эндхийн хувьсгалч үзэлтэй улсууд л байсан юм шиг байгаа юм.

Асуулт:-Дуганы барилга нь юу байсан юм бол?

Хариулт:-Мод байсан юм билээ.

Асуулт:-Одоо үлдэгдэл туурь гэхээр юм бий юу?

Хариулт:-Байхгүй. Юу ч байхгүй, чулуу ч байхгүй. Одоо тэнд нь айл өвөлжөөд, зусаад байшин барилга бариад одоо мэдэгдэх юм байхгүй болсон.

Асуулт:-Та Бүдүүний хурал, дуган гэж сонссон уу?

Хариулт:-Бүдүүний дуган гэдгийг сонсоогүй. **Алтантэвшиг** гээд дугантай байсан юм байна лээ, дээр үед. Жижигхэн дуган байсан юм байна лээ.

Асуулт:-Хаана байдаг юм бэ?

Хариулт:-Баруун бүдүүн гэж байгаа. Тэрний урд суваргатай толгой байгаа.

Асуулт:-Одоо суварга нь бий юу?

Хариулт:-Одоо суварга хийсэн юм гэж дуулдана лээ.

Асуулт:-Тэрний наад дор нь гэсэн үг үү?

Хариулт:-**Тэрэн** дээр л байсан юм гэсэн.

Асуулт:-Тэр суварга байгаа дээрээ юу?

Хариулт:-Тэнд байсан юм гэнэ лээ. Хөгшчүүл ярьдаг байсан юм. Энд жижигхэн дуган байсан юм гэж.

Асуулт:-Тэрнийг Бүдүүний дуган гэж тэмдэглэсэн байна.

Хариулт:- **Алтантэвшиг** гэж газар байгаа. Тэр яг манай хүүхдүүд сураглаж мэдсэн юм шиг байна лээ. Дээр үеийн улсуудаас. Тэнд дуган байсан, **тэрэн** дээр нь суварга босгосон гэж. Ноднин тэгж байсан. Би тэрээд чинь явж чадахгүй юм **чинь яахав**.

Асуулт:-Дэрст булан гэж газар хаана байдаг юм бэ?

Хариулт:-Дэрст булан гэж энэ Хушаат руу байна. Дарь эх ламын хийдийг та нар үзлээ гэж байна. Тэрний чинь яг наад дор харалдаа.

Асуулт:-Тэгэхдээ голынхоо наад талд?

Хариулт:-Голынхоо наад талд.

Асуулт:-Хушаат гээд яриад байна шүү дээ, тэрнээсээ хаана юм бэ? Хушаат орох уу, наана юмуу?

Хариулт:-Хушаатаас цаана.

Асуулт:-Хушаат дээрээсээ хүнээр заалгах уу?

Хариулт:-Хушаат бол **Мянган дарийн** дуган гэж байсан.

Асуулт:-Тэрний талаар та ярьж өгөхгүй юу?

Хариулт:-Ёстой сайн мэдэхгүй. Туурь нь бол бий. Сайхан өргөн туурь бий.

Асуулт:-Чулуун туурь уу?

Хариулт:-Чулуун туурь.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Тэнд ер нь хэд орчим лам байсан бол?

Хариулт:-Мэдэхгүй.

Асуулт:-Тэрнээс дээшээ өгсөөд **Сээрийнхээ** голд Шивэрт гэж газар байна уу?

Хариулт:-Байна.

Асуулт:-**Шивэртэд** бас дуган байсан уу?

Хариулт:-**Шивэртэд** байсан юм гэнэ лээ, жижигхэн дуган. Одоо бол тэрнийг чинь хагалаад тариан талбай болгочихсон. Ерөөсөө мэдэгдэх юм байхгүй. Газар нь их сайхан.

Асуулт:-Дэрст ууланд бас дуган байсан гэсэн?

Хариулт:-Дэрст ууланд дээр үед юу байсан гэж ярьдаг юм. Чухам түүхийнхээ судар номонд юу байдаг юм. **Цагаан толгойн** цаад талд их хүрээ байсан юм гэнэ лээ.

Асуулт:-Улаанбаатар уу?

Хариулт:-Тийм.

Асуулт:-Тэгээд удаагүй нүүгээд Дэрст булан гэдэгт чинь явчихсан гэж. Ямар ч судар бичигт билээ би бас нэг уншиж байсан юмаа.